



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 29 өдөр

Дугаар 1/152

Хархорин сум

Хорио цээрийн дэглэм тогтоох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.12, Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1.Сумын ой бүхий 2000 га талбайд "Гранд форест" ХХК ойн хортон шавж устгах тэмцлийн ажлыг гүйцэтгэх болсонтой холбогдуулан 8 дугаар багийн нутаг Бугат уул, Цагдуулт, Уртын ам, 7 дугаар багийн Шанхын гуруу гэх ойн сан бүхий газруудад 2024 оны 07 дугаар сарын 29-ны өдрөөс 2024 оны 8 дугаар сарын 05-ний өдрийг хүртэлх хугацаанд хорио цээрийн дэглэм тогтоосугай.

2.Хорио цээр тогтоосон ойн сан бүхий газарт гадаад, дотоодын аялагч, иргэд, мал оруулахгүй байхыг малчин, мал бүхий иргэд, аялагч нарт сурталчлан ажиллахыг багийн Засаг даргад үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн (Ц.Баатарсүрэн), Байгаль хамгаалагч (Н.Төгөлдөр) нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ОДГЭРЭЛ

401100303